

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.13. Шилэн дансны мэдээлэл	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Менежментийн захидал.....	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	13
1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	23



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.02.04 № 06/601
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БИЛГҮҮН
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2020\0221SAG49.Docx


01001050829

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.1. Оршил

Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Билгүүн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн санхүүгийн програм, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сайжруулах, орлогын хүлээн зөвшөөрөлтэй холбоотой бүртгэл тайлагналыг холбогдох заавар журмын дагуу хийх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Стандарт, хэмжил зүйн газар 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 25-наас 2020 оны 2 дугаар сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын Ахлах аудитор Б.Сэржмядаг, аудитор А.Даваадорж нар хариуцаж хэрэгжүүлэв.

Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2/378 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Стандарт, хэмжил зүйн газар үйл ажиллагааны эрхэм зорилгоо Монгол Улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэхэд оршино гэж тодорхойлсон байна.

Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдлыг хамгаалах, үндэсний үйлдвэрлэл, бүтээгдэхүүн ажил үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд стандартчилал, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалтын үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх;
- Нийгэм, эдийн засгийн хөгжлийг хэмжлийн нэгдмэл байдлыг хангах бодлогоор дэмжиж, Монгол Улсын хэмжлийн тогтолцоо, хэмжлийн нэгжийн үндэсний эталон, хууль эрхийн хэмжил зүйн техникийн чадавхыг нэмэгдүүлж олон улсын түвшинд хүргэх;
- Олон улсын шаардлагад нийцсэн тохирлын үнэлгээний байгууллагын итгэмжлэлийн тогтолцоог бий болгох, эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Бүтээгдэхүүн үйлчилгээний болон удирдлагын тогтолцоо (ISO 9001, ISO 14000 HACCP)-ны баталгаажуулалтын үйл ажиллагаагаар худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, тэдэнд зах зээл дээр шударга өрсөлдөх таатай нөхцөлийг бүрдүүлэх;
- Сорьцын баталгааг олон улсын түвшинд хүргэх, үнэт металлын сорьц тогтоох, эрдэнийн чулуу тодорхойлох үйлчилгээг олон улсын стандартын дагуу хийж хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хэмжил зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулга
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Стандарт, хэмжил зүйн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Стандарт, хэмжил зүйн газрын нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “EMERALD” программ хангамж ашигладаг байна.

Стандарт, хэмжил зүйн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Стандарт, хэмжил зүйн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй

нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 7,530.508.2 мянган төгрөгөөс тооцон 150,610.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөөгүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 652,072.1 мянган төгрөгөөр буюу 17.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	1.4	1.4
Авлага	107,636.1	126,470.9	18,834.8
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	633,475.9	1,438,505.7	805,029.8
Үндсэн хөрөнгө	2,939,063.7	2,767,269.7	(171,794.0)
Нийт хөрөнгө	3,680,175.7	4,332,247.8	652,072.1
Өр төлбөр	8,392.2	16,314.3	7,922.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,671,783.5	4,315,933.4	644,149.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,680,175.7	4,332,247.8	652,072.1

Авлага дансны үлдэгдэл өссөн нь төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлээс харилцагч 9 байгууллагад 38,151.7 мянган төгрөгийн үнэт цаас болон бусад бараа материал худалдан авахаар шилжүүлсэн, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 14,008.1 мянган төгрөг, дотоод хяналт шалгалтаар үнэт цаас дутагдаж холбогдох мэргэжилтнүүдээр буцаан төлүүлэхээр 5,180.8 мянган төгрөгийн авлага үүсгэн бүртгэснээс голлон шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд өмнөх онд үүссэн 2 харилцагч байгууллагатай холбоотой 17,106.0 мянган төгрөг, ММНБИ-д сургалтын төлбөрт урьдчилж шилжүүлсэн 2,000.0 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 805,029.8 мянган төгрөгөөр өссөн нь 2 аймгийн хэлтсийн барилгын дуусаагүй хөрөнгө оруулалт 780,000.0 мянган төгрөг, тусгай

зориулалтын хангамжийн материал 19,505.9 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ. Оны эцэст 19,505.9 мянган төгрөгийн тусгай зориулалтын хангамжийн материалыг төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлээс худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн байгаа нь хэрэгцээ шаардлагагүй бараа материал нөөцөлж, төсвийг үр ашиггүй зарцуулсан байх үр дагавартай байна.

Бараа материалын дансанд 2018-2019 оны хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 1,125,999.6 мянган төгрөгийн 2 хэлтсийн дуусаагүй барилга бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант оны элэгдлийн зардал 392,624.0 мянган төгрөг байгаагаас голлон шалтгаалжээ. Мөн туслах үйл ажиллагааны орлогоос 93,007.9 мянган төгрөг, Герман улсын Физик технологийн хүрээлэнгийн буцалтгүй тусламжаар эталон тусгай зориулалтын тоног төхөөрөмж 105,154.8 мянган төгрөг, өмнөх оны авлагаас 7,668.0 мянган төгрөг нийт 205,830.7 мянган төгрөгний үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Харин барилга байгууламж дансанд өмнөх оны дахин үнэлгээгээр 129,833.0 мянган төгрөгөөр үнэлэгдсэн газар эзэмших эрхийг бүртгэснийг аудитын хугацаанд холбогдох журмын дагуу биет бус хөрөнгө дансанд шилжүүлэн бүртгэснээс шалтгаалан бусад биет бус хөрөнгө нэмэгдсэн.

Өр төлбөр дансны үлдэгдэлд ХХОАТ-ын өглөг 12,647.7 мянган төгрөг, дүрэмт хувцасны үнэ 2,288.0 мянган төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,292,276.6 мянган төгрөг болж 644,149.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга байхгүй байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Стандарт, хэмжил зүйн газар тайлант онд 2,840,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 3,353,780.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 18.1 хувиар давуулан биелүүлсэн ба үүнээс 60,000.0 төгрөгийг урсгал зардлыг санхүүжүүлэхэд зарцуулж 3,293,780.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн ажилласан байна.

Төвлөрүүлэх орлого 513,780.9 мянган төгрөгөөр давсан нь хэмжих хэрэгсэл, шалгалт баталгаажуулалтын орлого 491,831.4 мянган төгрөг буюу 35.9 хувиар давж биелснээс шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 3,503,083.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,723,083.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 780,000.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталсан байна.

Нийт зардлын 3,443,083.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 60,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,484,143.0 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа ба зарцуулаагүй 18,939.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үүнээс урсгал зардалд 2,704,143.0 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын 2 төсөл, арга хэмжээнд 780,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсөв: Шинжлэх ухаан технологийн сангаас 14,850.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 199,536.5 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 23,615.9 мянган төгрөг нийт 238,003.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 65,700.9 мянган, ажилчдын нийгмийн асуудалд 59,970.0 мянган, хөрөнгийн зардалд 19,324.6 мянган, нийт 218,678.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 19,324.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 1,826,623.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,677,265.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,000.0 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 147,357.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 149,357.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. Санхүү, бүртгэлийн ажилтнуудад ММНБИ-ээс сургалт авахаар сургалтын төлбөрт урьдчилж шилжүүлсэн 2,000.0 мянган төгрөгийн он дамжсан авлага бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", мөн хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Акт тогтоох

2. Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой орлогуудаас хэмжих хэрэгсэл шалгалт, баталгаажуулалтын орлого, итгэмжлэлийн орлогыг түүвэрт хамруулан анхан шатны баримт руу хөөн шалгахад 96,611.0 мянган төгрөгийг авлагаар бүртгээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйл Санхүүгийн бүртгэл, стандарт 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна;

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3. Лабораторид зарцуулагдаагүй үлдсэн 6,943 ширхэг 1,041.4 мянган төгрөгийн үнэт цаасыг зарцуулснаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4. Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлээс харилцагч 8 байгууллагад 12,570,8 мянган төгрөгийн бараа материал авахаар шилжүүлж авлага үүсгэн бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйл Төсвийн зарлагын хэмнэлт 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй;

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

5. Цалинг зардлын хэмнэлтээс, 128 ажилтан, албан хаагчдад төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын дээд хэмжээнээс давсан 37,134.7 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байгаа нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох тухай” журмын 2.2-д “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Бүртгэл тайлагналтай холбоотой 1,677,265.6 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

1. Хэнтий аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн дуусаагүй хөрөнгө оруулалтын ажлын өмнөх оны үлдэгдэл 345,999.6 мянган төгрөг, тайлант оны санхүүжилт нийт 380,000.0 мянган төгрөг нийт 725,999.6 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтын ажил дуусаагүй, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөөгүй байхад дуусаагүй барилга байгууламж дансанд шилжүүлэн бүртгэсэн;
2. Дорнод аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн барилгын хөрөнгө оруулалтын санхүүжилт болох 400,000.0 мянган төгрөгийг эрх шилжүүлэх гүйлгээгээр ашиглагч байгууллагад шилжүүлснийг захиалагч талд хуримтлуулан бүртгээгүй;
3. Барилга байгууламж дансанд өмнөх онд дахин үнэлгээгээр нэмэгдсэн 2 байршилд байгаа 129,833.0 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг бүртгэсэн;
4. Үндсэн үйл ажиллагааны орлогыг 7,340.0 мянган төгрөгөөр, нэмэлт орлогыг 2,160.0 мянган төгрөгөөр тус тус илүү илэрхийлсэн, орлогын ангилал зөрүүтэй бүртгэсэн, эрх шилжүүлсэн хөрөнгийн санхүүжилт 400,000.0 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд тусгаагүй;
5. Барилга байгууламжийн элэгдлийн зардлыг 16,008.8 мянган төгрөгөөр илүү, бусад хөрөнгийн элэгдлийн зардлыг 9,964.2 мянган төгрөгөөр дутуу тооцоолсныг тус тус аудитын явцад залруулсан.

Аудитаар илэрсэн улсын бүртгэл, газар эзэмших гэрчилгээ, нягтлан бодох бүртгэлийн бодлоготой холбоотой зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Стандарт, хэмжил зүйн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулан ажилласан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан, тусгайлан аудитын дүгнэлт, зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Стандарт, хэмжил зүйн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Улсын бүртгэл, газар эзэмшлийн гэрчилгээтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Төв байрны газар эзэмших гэрчилгээний хугацаа 2016 онд дууссан, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд 2009 оноос хойш өөрчлөлт оруулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг 20.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2. Эрсдэл:

Өмч хөрөнгө эзэнгүйдэх, дотоод хяналт сул, бодитой оршин байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх

1.3. Өгсөн зөвлөмж:

Төв байрны газар эзэмших гэрчилгээний хугацаа сунгуулах, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд тухай бүр өөрчлөлт оруулж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн программтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тус байгууллагад ашиглагдаж байгаа санхүүгийн программ хангамж нь УСНББОУС болон Сангийн сайдын баталсан холбогдох заавар, журамтай бүрэн нийцээгүйгээс санхүүгийн тайлан, тодруулгууд нь эдийн засгийн ангилал зөрүүтэй, мэдээ тайлангууд үнэн зөв, иж бүрэн тайлагнагдахгүй, уялдаа холбоогүй Сангийн сайдын 2018 оны 47 тоот тушаалын 1 дүгээр хавсралтад заасан "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ыг хангахгүй байна;

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай уялдаагүй, шинээр нэмэгдсэн, өөрчлөгдсөн холбогдох хууль, журам, стандартын өөрчлөлтийг тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", мөн хуулийн 20 дугаар зүйлийн "Ерөнхий нягтлан бодогчийн эрх үүрэг"-ийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, холбогдох хууль, тогтоомж, стандарттай нийцэхгүй байх, санхүүгийн тайлан, мэдээ буруу илэрхийлэгдэх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн программ хангамж, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг УСНББОУС болон Сангийн сайдын баталсан холбогдох заавар, журамтай бүрэн нийцүүлэн шинэчилж өөрчлөх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>741,111,981.18</u>	<u>1,564,978,038.31</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	1,400.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	1,400.00
31140	Касс арилжааны банк	-	1,400.00
33	АВЛАГА	107,636,059.84	126,470,889.90
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		5,180,800.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	71,375,400.00	77,114,600.00
335	Бусад авлага	36,260,659.84	44,175,489.90
3351	Байгууллагаас авах авлага	36,260,659.84	44,175,489.90
35	БАРАА МАТЕРИАЛ	633,475,921.34	1,438,505,748.41
351	Түүхий эд материал	417,714,079.05	1,198,941,257.92
35110	Тусгай зориулалттай материал	28,498,104.80	28,416,854.14
35130	Эм боох материал		1,640,700.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	345,999,648.00	1,125,999,648.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	43,216,326.25	42,884,055.78
354	Хангамжийн материал	215,761,842.29	239,564,490.49
35410	Бичиг хэргийн материал	13,311,853.93	11,801,919.58
35450	Барилгын засварын материал	645,955.11	4,444,380.11
35470	Аж ахуйн материал		51,907,523.30
35480	Бусад хангамжийн материал	201,804,033.25	171,410,667.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,939,063,691.34</u>	<u>2,767,269,729.28</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,939,063,691.34	2,767,269,729.28
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	2,932,055,922.99	2,632,305,004.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,515,798,965.95	2,385,965,965.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	(410,458,349.78)	(562,370,208.02)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	141,246,666.66	141,246,666.66
39204	Хуримтлагдсан элэгдэл	(134,352,535.37)	(124,763,140.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,686,310,917.00	4,876,331,752.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,935,994,890.68)	(4,147,118,998.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	314,793,067.30	322,935,067.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	(248,669,365.29)	(268,856,482.26)
39214	Бусад үндсэн хөрөнгө	48,520,014.30	56,188,035.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	(45,138,567.10)	(47,253,654.50)
393	Биет бус хөрөнгө	7,007,768.35	134,964,724.96
39301	Програм хангамж	8,326,964.41	8,326,964.41
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,874,637.57)	(7,876,964.41)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,710,949.09	138,543,949.09
39304	Хуримтлагдсан элэгдэл	(2,155,507.58)	(4,029,224.13)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,680,175,672.52</u>	<u>4,332,247,767.59</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>8,392,200.00</u>	<u>16,314,349.80</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,392,200.00	16,314,349.80
413	Өглөг	-	968,618.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	968,618.00

4136	Бусад өглөг	8,392,200.00	15,345,731.80
41361	Байгууллагад төлөх өглөг	3,492,200.00	13,057,731.80
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	4,900,000.00	2,288,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,671,783,472.52	4,315,933,417.79
51	Засгийн газрын хувь оролцоо	3,671,783,472.52	4,315,933,417.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,711,577,835.39	3,711,577,835.39
51101	Өмч: - төрийн	3,711,577,835.39	3,711,577,835.39
512	Хуримтлагдсан үр дүн	(768,957,126.90)	(124,807,181.63)
51210	Өмнөх үеийн үр дүн	(851,784,658.87)	(768,957,126.90)
51220	Тайлант үеийн үр дүн	82,827,531.97	644,149,945.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	729,162,764.03	729,162,764.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,680,175,672.52	4,332,247,767.59

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,618,827,866.76	8,232,309,155.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,583,919,315.76	3,890,127,304.27
120	Нийтлэг татварын бус орлого	3,583,919,315.76	3,890,127,304.27
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,583,919,315.76	3,890,127,304.27
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,563,200,935.76	3,365,144,254.40
1200042	Туслах үйл ажиллагаанаас санхүүжих	17,765,380.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,953,000.00	124,983,049.87
	Үнэ төлбөргүй барилга		400,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,034,908,551.00	4,342,181,851.15
131	Улсын төсвөөс санхүүжих	4,034,908,551.00	3,057,933,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,015,637,248.00	2,663,083,800.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,004,421,303.00	
131005	Хөрөнгийн санхүүжилт		380,000,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	14,850,000.00	14,850,000.00
131	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	199,536,556.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		199,536,556.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	1,084,711,495.15
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/		1,084,711,495.15
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,488,299,969.02	7,588,159,210.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,488,299,969.02	7,588,159,210.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,618,489,517.91	2,643,653,906.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,395,071,410.79	1,539,059,100.00
210101	Үндсэн цалин	1,395,071,410.79	1,185,716,200.00

210102	Нэмэгдэл		245,938,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		107,404,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	165,423,482.12	192,919,000.00
210201	Тэтгэврийн даатгал	110,968,193.00	131,185,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,096,769.00	15,433,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,012,223.12	12,346,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,758,790.00	3,086,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	27,587,507.00	30,866,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,713,904.35	82,539,600.00
210301	Гэрэл, цахилгаан	41,337,157.13	44,550,241.32
210302	Түлш, халаалт	29,423,677.21	30,594,337.08
210303	Цэвэр, бохир ус	7,718,234.01	7,395,021.60
210304	Байрны түрээс	12,234,836.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	75,516,954.05	59,674,178.67
210401	Бичиг хэрэг	20,535,904.95	26,129,433.67
210402	Тээвэр, шатахуун	15,730,186.49	9,365,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,287,847.60	20,687,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,070,000.00	1,260,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,111,132.00	2,231,845.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	12,781,883.01	
2105	Нормативт зардал	95,188,695.76	80,746,080.66
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	95,188,695.76	79,778,080.66
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		968,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	162,769,807.64	15,500,910.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	9,572,400.00	
210604	Урсгал засвар	153,197,407.64	15,500,910.00
2107	Томилолт, зочны зардал	52,862,614.60	29,624,758.66
210701	Гадаад албан томилолт	16,037,650.00	3,000,000.00
210702	Дотоод албан томилолт	33,824,964.60	26,624,758.66
